



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А125

Мандалговь

"Нэгдүгээрт хүүхэд" уриалга гаргах тухай

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5, 6, 7, 8, 9 дүгээр зүйл, 18 дугаар зүйлийн 18.1.5, 18.1.6, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төсвийн төвлөрүүлэн захирагчаас Төсвийн шууд захирагчтай байгуулсан 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхэдтэй зүй бус харилцах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор "Нэгдүгээрт хүүхэд" уриалгыг 2022 оны үйл ажиллагаанд ашиглах, сурталчилах, таниулах үйл ажиллагааг зохион байгуулсугай.

2. "Нэгдүгээрт хүүхэд" уриалга гаргахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 2,452,950 (Хоёр сая дөрвөн зуун тавин хоёр мянга есөн зуун тавь) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тухай бүр даргын дэргэдэх зөвлөлд танилцуулж ажиллахыг нийт албан хаагчдад даалгасугай.


ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

482201049

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2022 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн
11/25 тоот тушаалын 01 дугаар хавсралт



"НЭГДҮГЭЭР ХҮҮХЭД" УРИАЛГА ХЭВЛҮҮЛЭХЭД
ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Зардлын ангилал	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Лед гэрэл	м2	490,590	5	2,452,950